**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2025/100/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК
Утас:99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# АГУУЛГА


1. АУДИТЫН ДҮГНЭЛТ ........ 3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ **Error! Bookmark not defined.**
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 11
3.2.Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 12
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 14
3.5.3 Нэмэлт төсөв: ........ 15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ........ 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 15
4.1 Ерөнхий зүйл ........ 15
4.2. Материаллаг байдал ........ 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 18
5.1 Төлбөрийн акт ........ **Error! Bookmark not defined.**
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| ААН | Аж ахуй нэгж |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № СЭА-2025/100/НА-СТА-ТШЗ

танай ______________-ны № ________________-т

ЕРӨӨ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Л.БОЛОРТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Боловсролын яамнаас зарласан *“Ерөнхий боловсролын сургуульд цахим анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж”*-ийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендерт шалгарсан Максим Консалтинг ХХК-иас 84,997.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авч хөрөнгийн орлогоор бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан



432502090

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

# 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 421,108,383.23 | 723,085,506.29 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 189,280,330.79 | 477,559,853.38 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 189,280,330.79 | 477,559,853.38 |
| 3121 | Төгрөг | 189,280,330.79 | 477,559,853.38 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 189,280,330.79 | 477,559,853.38 |
| 33 | АВЛАГА | 436,974.73 | |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 436,974.73 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 231,391,077.71 | 245,525,652.91 |
| 351 | Түүхий эд материал | 23,532,826.25 | 23,532,826.25 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 23,532,826.25 | 23,532,826.25 |
| 353 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,641,960.00 | |
| 354 | Хангамжийн материал | 203,216,291.46 | 221,992,826.66 |
| 3542 | Аж ахуйн материал | 80,089,828.34 | 75,877,128.34 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 750,000.00 | 750,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 13,000,000.00 | 20,599,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 1,511,160.00 | 188,360.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 107,865,303.12 | 124,578,338.32 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 12,495,081,948.09 | 12,706,174,927.45 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12,495,081,948.09 | 12,706,174,927.45 |
| 392 | Биет хөрөнгө | 12,411,743,614.45 | 12,624,000,760.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 12,316,891,769.00 | 12,316,891,769.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -452,638,027.49 | -616,932,459.05 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,610,500.00 | 18,610,500.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,610,500.00 | -18,610,500.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 538,549,394.82 | 1,001,456,665.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -168,912,188.86 | -259,096,025.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 145,823,951.66 | 166,824,751.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -75,118,253.93 | -88,264,646.43 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 16,887,852.00 | 16,887,852.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -7,895,800.00 | -7,895,800.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 75,289,854.00 | 75,289,854.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -24,385,387.05 | -28,992,149.35 |
| 39217 | Ном | 47,250,450.30 | 47,830,948.50 |
| 393 | Биет бус хөрөнгө | 83,338,333.64 | 82,174,167.04 |
| 39301 | Програм хангамж | 8,803,000.00 | 8,803,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -6,474,666.36 | -7,638,832.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 81,010,000.00 | 81,010,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 12,916,190,331.32 | 13,429,260,433.74 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 46,040,042.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 46,040,042.00 |
| 413 | Өглөг | | 46,040,042.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 4136 | Бусад өглөг | | 46,040,042.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 46,040,042.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 12,916,190,331.32 | 13,383,220,391.74 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 12,916,190,331.32 | 13,383,220,391.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 570,012,254.67 | 570,012,254.67 |
| 51101 | Өмч: - төрийн | 570,012,254.67 | 570,012,254.67 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 12,138,591,319.28 | 12,605,621,379.70 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 12,138,591,319.28 | 12,138,591,319.28 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 467,030,060.42 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 207,586,757.37 | 207,586,757.37 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 12,916,190,331.32 | 13,429,260,433.74 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,478,944,842.30 | 3,614,170,335.89 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 249,845,044.40 | 399,078,269.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 249,845,044.40 | 399,078,269.70 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 242,426,616.40 | 386,683,269.70 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,418,428.00 | 300,000.00 |
| 120009 | Бусад орлого | | 12,095,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,229,099,797.90 | 3,215,092,066.19 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,717,150,300.00 | 2,670,801,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,717,150,300.00 | 2,670,801,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,900,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,900,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 510,049,497.90 | 544,290,666.19 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 510,049,497.90 | 544,290,666.19 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,403,608,888.54 | 3,147,140,275.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,403,608,888.54 | 3,147,140,275.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,316,418,698.54 | 3,054,815,091.72 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,233,059,221.27 | 1,830,468,235.04 |
| 210101 | Үндсэн цалин | 899,073,599.27 | 1,195,064,640.09 |
| 210102 | Нэмэгдэл | 288,200,143.00 | 561,286,607.95 |
| 210104 | Урамшуулал | 45,785,479.00 | 74,116,987.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 146,577,303.73 | 224,366,091.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,478,054.73 | 154,333,943.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,633,064.00 | 18,031,854.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,169,242.00 | 9,185,041.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,185,773.00 | 8,563,071.81 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,111,170.00 | 34,252,180.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 498,156,897.90 | 531,698,066.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 56,483,697.90 | 64,515,384.19 |
| 210302 | Түлш, халаалт | 438,187,200.00 | 452,419,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,486,000.00 | 14,763,682.00 |
| 2105 | Нормативт зардал | 60,336,764.00 | 57,373,751.00 |
| 210502 | Хоол, хүнс | 60,336,764.00 | 57,373,751.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,258,500.00 | 11,105,220.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,258,500.00 | 11,105,220.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,012,965.00 | 19,674,623.30 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,335,500.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,677,465.00 | 19,674,623.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 354,017,046.64 | 380,129,104.54 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 36,553,778.00 | 86,820,664.70 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17,708,900.00 | 19,912,850.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 299,754,368.64 | 273,395,589.84 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 87,190,190.00 | 92,325,183.75 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 87,190,190.00 | 92,325,183.75 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 87,190,190.00 | 92,325,183.75 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 75,335,953.76 | 467,030,060.42 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 75,335,953.76 | 467,030,060.42 |

## 2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2,236,518,225.90 | 3,227,487,066.19 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,418,428.00 | 12,395,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,418,428.00 | 12,395,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,418,428.00 | 300,000.00 |
| 120009 | Бусад орлого | | 12,095,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,229,099,797.90 | 3,215,092,066.19 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,717,150,300.00 | 2,670,801,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,717,150,300.00 | 2,670,801,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,900,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,900,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 510,049,497.90 | 544,290,666.19 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 510,049,497.90 | 544,290,666.19 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,106,461,761.63 | 2,870,277,785.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,106,461,761.63 | 2,870,277,785.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,014,629,611.63 | 2,782,592,861.85 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,231,210,238.00 | 1,829,557,932.31 |
| 210101 | Үндсэн цалин | 896,343,821.00 | 1,152,436,017.36 |
| 210102 | Нэмэгдэл | 289,080,938.00 | 603,004,927.95 |
| 210104 | Урамшуулал | 45,785,479.00 | 74,116,987.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,696,508.73 | 224,366,091.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,478,054.73 | 154,333,943.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,752,269.00 | 18,031,854.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,169,242.00 | 9,185,041.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,185,773.00 | 8,563,071.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,111,170.00 | 34,252,180.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 498,156,897.90 | 531,698,066.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 56,483,697.90 | 64,515,384.19 |
| 210302 | Түлш, халаалт | 438,187,200.00 | 452,419,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,486,000.00 | 14,763,682.00 |
| 2105 | Нормативт зардал | 61,671,624.00 | 56,194,579.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,671,624.00 | 56,194,579.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,892,600.00 | 12,592,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,892,600.00 | 12,592,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,572,965.00 | 28,498,763.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,335,500.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,237,465.00 | 28,498,763.70 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,428,778.00 | 99,684,829.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,099,878.00 | 78,596,179.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,328,900.00 | 21,088,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 91,832,150.00 | 87,684,923.75 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 91,832,150.00 | 87,684,923.75 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 91,832,150.00 | 87,684,923.75 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 130,056,464.27 | 357,209,280.59 |

| | | | |
|---|---|---|---|
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 46,756,700.00 | 68,929,758.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 46,756,700.00 | 68,929,758.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 46,756,700.00 | 68,929,758.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -46,756,700.00 | -68,929,758.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 83,299,764.27 | 288,279,522.59 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 189,280,330.79 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 477,559,853.38 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 570,012,254.67 | 207,586,757.37 | 12,138,591,319.28 | 12,916,190,331.32 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 467,030,060.42 | 467,030,060.42 |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 570,012,254.67 | 207,586,757.37 | 12,605,621,379.70 | 13,383,220,391.74 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,416,767,396.98 | 2,939,207,543.60 | 477,559,853.38 | 86.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,416,767,396.98 | 2,870,277,785.60 | 546,489,611.38 | 84.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,305,446,996.98 | 2,782,592,861.85 | 522,854,135.13 | 84.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,188,535,900.00 | 1,829,557,932.31 | 358,977,967.69 | 83.6 |
| 210101 | Үндсэн цалин | 1,417,120,000.00 | 1,152,436,017.36 | 264,683,982.64 | 81.3 |
| 210102 | Нэмэгдэл | 728,465,700.00 | 603,004,927.95 | 125,460,772.05 | 82.8 |
| 210104 | Урамшуулал | 42,950,200.00 | 74,116,987.00 | -31,166,787.00 | 172.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 273,567,100.00 | 224,366,091.65 | 49,201,008.35 | 82.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 186,025,600.00 | 154,333,943.39 | 31,691,656.61 | 83.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,885,400.00 | 18,031,854.81 | 3,853,545.19 | 82.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,942,700.00 | 9,185,041.28 | 1,757,658.72 | 83.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,942,700.00 | 8,563,071.81 | 2,379,628.19 | 78.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 43,770,700.00 | 34,252,180.36 | 9,518,519.64 | 78.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 531,698,066.19 | 531,698,066.19 | | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 64,515,384.19 | 64,515,384.19 | | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 452,419,000.00 | 452,419,000.00 | | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,763,682.00 | 14,763,682.00 | | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 78,327,900.00 | 56,194,579.00 | 22,133,321.00 | 71.7 |
| 210502 | Хоол, хүнс | 78,327,900.00 | 56,194,579.00 | 22,133,321.00 | 71.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,592,600.00 | 12,592,600.00 | | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 12,592,600.00 | 12,592,600.00 | | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,150,400.00 | 28,498,763.70 | 25,651,636.30 | 52.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 54,150,400.00 | 28,498,763.70 | 25,651,636.30 | 52.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 166,575,030.79 | 99,684,829.00 | 66,890,201.79 | 60.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 145,122,830.79 | 78,596,179.00 | 66,526,651.79 | 54.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,452,200.00 | 21,088,650.00 | 363,550.00 | 98.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 111,320,400.00 | 87,684,923.75 | 23,635,476.25 | 78.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 111,320,400.00 | 87,684,923.75 | 23,635,476.25 | 78.8 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 111,320,400.00 | 87,684,923.75 | 23,635,476.25 | 78.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 68,929,758.00 | -68,929,758.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | | 68,929,758.00 | -68,929,758.00 | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,416,767,396.98 | 3,227,487,066.19 | -3,227,487,066.19 | |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,859,136,730.79 | 2,670,801,400.00 | -2,670,801,400.00 | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,670,801,400.00 | 2,670,801,400.00 | -2,670,801,400.00 | |
| 131009 | Оны эхний үлэгдлээс санхүүжих | 188,335,330.79 | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 544,290,666.19 | 544,290,666.19 | 0.00 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 544,290,666.19 | 544,290,666.19 | 0.00 | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 1,245,000.00 | 300,000.00 | 945,000.00 | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | 12,095,000.00 | 12,095,000.00 | - | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 189,280,330.79 | -945,000.00 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 477,559,853.38 | -477,559,853.38 | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ерөө сумын ерөнхий боловсролын сургууль нь *"Хамтын оролцоотойгоор суралцахуйн суурь чадварыг ахиулж, эрүүл зөв дадал хэвшилтэй, ёс зүйг эрхэмлэдэг сурагчдыг төлөвшүүлье "* гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн орчинд хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй материаллаг болон нийгэм сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлж хүүхдийн эрхийг хангаж ажиллах;
- Багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлэг, эцэг эх, олон нийтийн байгууллагын хамтын оролцоотойгоор суралцахуйн суурь чадварыг ахиулах;
- Өглөөний цайгаа тогтмол ууж, дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэх;
- Сургуулийн дүрмийг баримтлах;

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор "Хувьсах зардал болон гүйцэтгэл,үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор"Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл,чанар,үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 513,070.1 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 189,280.3 | 477,559.9 | 288,279.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Авлага | 437.0 | - | (437.0) |
| Бараа материал | 231,391.1 | 245,525.7 | 14,134.6 |
| Үндсэн хөрөнгө | 12,495,081.9 | 12,706,174.9 | 211,093.0 |
| ***Нийт хөрөнгө*** | 12,916,190.3 | 13,429,260.4 | 513,070.1 |
| Өглөг | - | 46,040.0 | 46,040.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 12,916,190.3 | 13,383,220.4 | 467,030.1 |
| ***Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн*** | 12,916,190.3 | 13,429,260.4 | 513,070.1 |

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 477,559.9 мянган төгрөг болж 288,279.5 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 245,525.7 мянган төгрөг болж 14,134.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 206,656.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын яамнаас 13,842.1 мянган төгрөгийн түрээсийн ном , Дэлхийн зөн ОУБ-аас 3,322.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, үйл ажиллагаанд 209,686.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 13,733,605.3 мянган төгрөг болж 484,488.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 38,956.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендерт шалгарсан Максим Консалтинг ХХК-иас цахим ангийн 84,997.0 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авсан, Боловсролын яамнаас 360,534.7 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй авч данс бүртгэлд тусгасан зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 1,027,430.4 мянган төгрөг бөгөөд 12,706,174.9 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр данс 46,040.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахим ангийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авснаас шалтгаалсан байна.

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,765,852.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 547,628.2 мянган төгрөг, нийт 3,313,480.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 683,717.8 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 8,682.7 мянган төгрөгөөр бууруулж, төсвийг 2,621,080.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,670,801.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 544,290.7 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 189,280.3 мянган төгрөгийн, үйл ажиллагааны орлогоос 12,395.0 мянган төгрөг нийт **3,416,767.4** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 683,711.9 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 8,682.7 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 95,417.4 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн зардлыг 54,150.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 41,267.0 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 11,212.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж
- Тогтмол зардлыг 3,337.5 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт **3,416,767.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 2,939,207.5 мянган төгрөгийг зарцуулж, 477,559.9 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,939,207.5 мянган төгрөг буюу 86.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр | д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **71802 Ерөнхий боловсрол** | 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 5,357.6 | 5,357.6 | - | 100.0 |
| | | 2 | 80233-Хүүхэд хамгаалал | 5,660.0 | 5,104.0 | 556.0 | 90.2 |
| | | 3 | 80312- Сургалт семинар | 6,126.9 | 4,391.5 | 1,735.4 | 71.7 |
| | | 4 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 5,357.6 | 5,357.4 | 0.2 | 100.0 |
| | | 5 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 111,320.5 | 87,684.9 | 23,635.5 | 78.8 |
| | | 6 | 81806- Дотуур байрны үйлчилгээ | 262,094.8 | 179,011.9 | 83,082.9 | 68.3 |
| | | 7 | 81816- Зөв монгол хүүхэд | 48,416.1 | 44,516.8 | 3,899.3 | 91.9 |
| | | 8 | 81823- Боловсролын багшийн сургалт | 16,072.6 | 10,310.0 | 5,762.6 | 64.1 |
| | | 9 | 81827- Бичиг үсгийн боловсрол | 1,337.2 | - | 1,337.2 | - |
| | | 10 | 81834- Боловсролын стандарт сургалт | 2,344,365.9 | 1,989,407.7 | 354,958.2 | 84.9 |
| | | 11 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 42,656.0 | 42,656.0 | - | 100.0 |
| | | 12 | 81848-Сурах бичгийн түрээс | 629.5 | - | 629.5 | - |
| | | 13 | 81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 9,859.2 | 7,924.1 | 1,935.1 | 80.4 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 14 | 83603- Дээд шатны төсвөөс | 10,027.8 | 10,000.0 | 27.8 | 99.7 |
| | | 15 | 81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн өөрийн орлого | 3,195.0 | 3,195.0 | - | 100.0 |
| | | 16 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 544,290.7 | 544,290.7 | - | 100.0 |
| | Нийт | | | 3,416,767.4 | 2,939,207.5 | 477,559.9 | 86.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *"Чиглэл хүргүүлэх тухай"* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

